

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ХЭЛТЭС**

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН
ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР**

2020 он

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

/Нэмэлт, өөрчлөлт/

Нэг.Оршил

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн даган мөрдөнө.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль нь 6 бүлэг, 24 зүйлтэй.

Хоёр: Хуулийн агуулга

Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар төрийн тусгай хамгаалалт, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг анх удаа хуульчлан тогтоосон нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд энэ хугацаанд тус хуульд 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Хуулийг дагаж мөрдсөнөөс хойшхи 25 жилийн хугацаанд улс орны эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон гадаад харилцаанд гарсан хөгжил, шинэчлэл, өөрчлөлтийн улмаас төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зарим асуудал тулгамдаж байгааг шийдвэрлэх шаардлага тулгарчээ.

Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын газар хуулиар төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн аюулгүй байдлыг нь хангах зорилгоор төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг.

Харин тагнуулын байгууллага нь хуулиар тагнуулын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Төрийн тусгай хамгаалалтын газрыг өөр чиг үүрэгтэй байгууллагын даргын дэргэд ажиллуулахаар тогтоосон нь нэг талаар Монгол Улсын тагнуулын байгууллага төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулдаг гэх ойлголтыг бий болгодог бол нөгөө талаар гадаад улсын дээд, өндөр хэмжээний зочны хамгаалалтын үед тухайн улсын холбогдох байгууллагатай хамгаалалтыг хамтран хэрэгжүүлэхэд харилцан итгэлцэл үүсэхгүй хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэдэг.

Энэ чиглэлээр гадаадын 54 улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаар судалгаа хийж үзэхэд 48 улсын төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь тагнуулын байгууллагаас тусдаа, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулдаг байна.

Төрийн тусгай хамгаалалтын бодлого нь хамгаалалтын арга тактик, хүч хэрэгсэл, хөрөнгө санхүү, нөөц боломж гэсэн бүх асуудлыг нэгтгэсэн цогц асуудал боловч Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар тэдгээрийг хооронд салгаж, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга болон тагнуулын байгууллагын даргад хуваан хариуцуулсан нь оновчгүй байсан байна.

Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын газар нь гадаад улсын ижил төстэй байгууллагаас туршлага судлах, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, ажилтан, алба хаагчийг сургалтад хамруулах зэрэг чиглэлээр холбогдох ажлуудыг төлөвлөдөг

боловч санхүүгийн боломж, дээд шатны байгууллагын шийдвэр, гадаад орнуудын адил чиг үүргийн байгууллагуудын харилцах байр суурь зэргээс хамааран зорилтот түвшиндээ хүрч чадахгүй, улмаар гадаад орнуудын хамгаалалтын байгууллагуудаас хөгжлийн хувьд хоцрох нөхцөлийг бий болгож байжээ.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаар ажиллаж байсан иргэнийг тухайн албан тушаалыг эрхэлсэн хугацаанаас үл хамааран тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа дууссанаас эхлэн 4 жилийн хугацаанд үргэлжлүүлэн хамгаалахаар холбогдох хуулиудад зохицуулсан нь төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагын ачааллыг нэмэгдүүлж, хүч хэрэгсэл, техник хангамжийн нөөцийг сулруулахын зэрэгцээ улсын төсөвт зардал ихээр гаргах нөхцөл болж байгаа тул тухайн иргэдийн хамгаалалтад үргэлжлүүлэн байх хугацааг хамгаалалтыг хэрэгжүүлэх үндэслэл, зорилгод нийцүүлэн бусад хуулийн зохицуулалттай уялдуулж оновчтой тогтоох шаардлагатай байсан.

Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судлах судалгаагаар Төрийн тусгай хамгаалалтын газрыг тагнуулын байгууллагаас тусдаа, бие даасан байдлаар өөрчлөн зохион байгуулснаар Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд учирч байгаа дээрх хүндрэлүүд арилж, хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна гэж хууль санаачлагчийн зүгээс үзжээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль нь 6 бүлэг, 24 зүйл, 149 хэсэг, заалттай ба үүнээс нийт 39 хэсэг, заалтад буюу хуулийн 26,2 хувьд ямар нэгэн хэмжээгээр нэмэлт, өөрчлөлт орохоор байсан. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д зааснаар тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт ороогүй тул нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд зарчмын чанартай дараахь өөрчлөлтүүдийг тусгасан байна. Үүнд:

1.Хуулийн гуравдугаар бүлэг:

Төрийн тусгай хамгаалалтын газрын хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой тусгасан хэдий ч тус байгууллагыг чиг үүргийн хувьд харилцан адилгүй Тагнуулын төв байгууллагын даргын дэргэд байхаар зохицуулсан байсныг цаашид Засгийн газрын тохируулагч агентлаг байх өөрчлөлт оруулсан. Уг өөрчлөлт орохтой холбогдуулан байгууллагын болон даргын эрх, үүрэгт хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн зарим өөрчлөлтийг тусгасан.

2. Хуулийн дөрөвдүгээр бүлэгт:

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой зарим асуудал нь Тагнуулын байгууллагын тухай хуулийн 22, 23, 25, 26 дугаар зүйлийн холбогдох заалтаар зохицуулагддаг байсныг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар зохицуулдаг байхаар нэмж тусгасан.

3. Хуулийн тавдугаар бүлэгт:

Төрийн тусгай хамгаалалтын газрыг бие даасан статустай болгохтой холбогдуулан төрийн тусгай хамгаалалтад тагнуулын байгууллагын хүлээх зарим үүрэгт өөрчлөлт оруулах, тухайлбал, Тагнуулын төв байгууллагын дарга болон Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга нарын хамтран баталсан журмаар хамтын ажиллагааг зохицуулдаг байхаар өөрчлөлтийг тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараахь үр дагавар бий болно гэж үзжээ:

1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн зарим тодорхойгүй зохицуулалтын хийдэл арилна;

2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын тогтолцоог тодорхой болгосноор тус байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх нөхцөл хангагдана;

3.Төрийн тусгай хамгаалалтыг иж бүрэн байх зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх уйл ажиллагаа илүү оновчтой болно.

Хуулийн зөрчил хийдлийг арилган төрийн тусгай хамгаалалтыг найдвартай, иж бүрэн хэрэгжүүлэх, орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, зөрчил арилгах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэж хууль санаачлагч үзэж тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллагад өргөн мэдүүлж, Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлагдсан учир цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчид хамаарах зүйл, заалтаас түүвэрлэн энэхүү мэдээллийг боловсрууллаа.

Хуулийг <https://legalinfo.mn/law/details/499> холбоосоор орж дэлгэрэнгүй үзнэ үү.

---oOo---

ГАРЧИГ

Нэг. Оршил

Хоёр. Хуулийн агуулга

Гурав. Хуулийн зарим зохицуулалтаас

Дөрөв. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасны дагуу дагалдан гарах эрх зүйн актууд

ГУРАВ:ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТААС

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**

10 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын байгууллага

<i>2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>	
1	Төрийн тусгай хамгаалалтын байгууллага /цаашид “Төрийн тусгай хамгаалалтын газар” гэх/ нь төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.
2	Төрийн тусгай хамгаалалтын газар хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын болон дүн шинжилгээний нэгжтэй байх бөгөөд зохион байгуулалтын бүтцийг төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн Засгийн газар тогтооно.
3	Төрийн тусгай хамгаалалтын газар туг, бэлгэ тэмдэгтэй байна. Туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална.
4	Төрийн тусгай хамгаалалтын газар тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
5	Төрийн тусгай хамгаалалтын газрын даргаар Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна төрийн тусгай албанд 16-аас доошгүй жил, үүнээс төрийн тусгай хамгаалалтын албанд 5-аас доошгүй жил ажилласан, удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдтэй зөвшилцөн Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.
6	Төрийн тусгай хамгаалалтын газрын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно.
7	Төрийн тусгай хамгаалалтын газар улсын төсвөөс санхүүжнэ.
8	Төрийн тусгай хамгаалалтын газрын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.
<p><i>Нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө Төрийн тусгай хамгаалалтын байгууллага Тагнуулын төв байгууллагын даргын дэргэд байхаар зохицуулсан байсныг өөрчилж, Засгийн газрын тохируулагч агентлаг байхаар энэ зүйлд тусгасан. Уг өөрчлөлт орохтой холбогдуулан байгууллагын болон даргын эрх, үүрэгт хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлсэн.</i></p>	

11 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын газрын эрх, үүрэг

<i>1995 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>
-	9.Хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал,

	зөвлөгөөн явагдах танхим, хамгаалуулагчийн ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл болон түр байрлах орон байр, албан тасалгаанд техникийн үзлэг, шалгалт хийх. /Шинээр нэмсэн/
2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	

12 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрх

Д/д	2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт	
1	Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрх /Энэ зүйлийг өөрчлөн найруулсан/	Төрийн тусгай хамгаалалтын газрын хүний нөөцийг бэлтгэх, зэвсэг, техникээр хангах, бэхжүүлэх талаарх саналаа Засгийн газарт танилцуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
2		Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;
3		Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасан техникийн үзлэг, шалгалт хийх зөвшөөрөл олгох;
4		Батлагдсан төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;
5		Хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу албан хаагчийг томилох, чөлөөлөх, цэргийн цол олгох, бууруулах, хураах, сэргээх, шагнаж урамшуулах, ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх;
6		Төрийн тусгай хамгаалалтад оролцож байгаа бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;
7		Байгууллагыг төлөөлөн дотоод, гадаадын байгууллагатай харилцан ажиллах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН АЛБА ХААГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ОНЦЛОГ

13 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч

1995 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт
-	3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ. /Шинээр нэмсэн/
-	4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална. /Шинээр нэмсэн/

-	5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газар батална. /Шинээр нэмсэн/
---	--

16 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

Д/д	<i>2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>	
1	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа <i>/Энэ зүйлийг өөрчлөн найруулсан/</i>	Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.
2		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг захирах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.
3		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдүүлэг авах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын газрын даргад мэдэгдэнэ.
4		Гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын алба хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул учирч болзошгүй бодитой нөхцөл байдал бий болсон тохиолдолд тэдгээрийг хамгаалалтад авч болно.
5		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс Төрийн албаны тухай хуулийн 57.2.3-т заасан цалин, нэмэгдлээс бүрдэнэ.
6		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.
7		Төрийн тусгай хамгаалалтын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээг Засгийн газар тогтооно.
8		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн амралт олгох ба төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.
9		Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжид ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг төрийн тусгай хамгаалалтын газар хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.
10		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай адилтган тооцно.
11		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4

		сартай дүйцүүлэн тооцно.
12		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжид зааснаар зохицуулна.
13		Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хуульд заасан бусад баталгаагаар хангагдана.
<p><i>Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой зарим асуудал нь Тагнуулын байгууллагын тухай хуулийн 22, 23, 25, 26 дугаар зүйлийн холбогдох заалтаар зохицуулагддаг байсныг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар зохицуулдаг байхаар тусгасан.</i></p>		

ТАВДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТАЛААР ТАГНУУЛ, ЦАГДАА БОЛОН БУСАД
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНИЙ ХҮЛЭЭХ

18 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын үүрэг

Д/д	<i>2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>	
1	Тагнуулын байгууллагын үүрэг <i>/Энэ зүйлийг өөрчлөн найруулсан/</i>	Тагнуулын байгууллага хамгаалуулагчийн аюулгүй байдал болон хамгаалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллээр төрийн тусгай хамгаалалтын газрыг хангаж, шаардлагатай бусад дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.
2		Тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газрын харилцан ажиллах, мэдээлэл солилцох журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын даргатай хамтран батална.
3		Тагнуулын байгууллагын орон нутаг дахь салбар, нэгж тухайн орон нутагт хэрэгжүүлэх төрийн тусгай хамгаалалтад хамтран оролцох цагдаагийн болон бусад байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж төрийн тусгай хамгаалалтын газарт дэмжлэг үзүүлнэ.
<p><i>Төрийн тусгай хамгаалалтын газрыг бие даасан статустай болгохтой холбогдуулан төрийн тусгай хамгаалалтад тагнуулын байгууллагын хүлээх зарим үүрэгт өөрчлөлт оруулж өгсөн.</i></p>		

22 дугаар зүйл. Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх

<i>1995 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>
6.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх зааврыг <i>Тагнуулын төв байгууллагын</i> дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.	6.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх зааврыг Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

**ДӨРӨВ. ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ЗААСНЫ ДАГУУ ДАГАЛДАХ ГАРАХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ТУХАЙ**

№	Журам, зааврын нэр	Батлах субъект	Хуулийн заалт
1	Хамгаалалтын зэрэглэл тус бүрийн онцлогт тохирсон хүч хэрэгслийн хэмжээ, тэдгээрийг хамгаалалтын тухайн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулах журам	Засгийн газар	9 дүгээр зүйлийн 9.3
2	Төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам	Засгийн газар	10 дүгээр зүйлийн 10.3
3	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журам	Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар	13 дугаар зүйлийн 13.4
4	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн дүрэм	Засгийн газар	13 дугаар зүйлийн 13.5
5	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх журам	Монгол Улсын Ерөнхийлөгч	14 дүгээр зүйлийн 14.2
6	Тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газрын харилцан ажиллах, мэдээлэл солилцох	Тагнуулын ерөнхий газрын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга хамтран	18 дугаар зүйлийн 18.2
7	Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх заавар	Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран	22 дугаар зүйлийн 22.6

---oOo---